

БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛ, ТҮҮНИЙ ТҮВШИН

**Б.Жадамбаа (МУБИС), Б.Болормаа (МУБИС)
Л.Энхбаяр (МУБИС)**

Эрт дээр үеэс өнөөг хүртэл бичиг үсгийн боловсролын тухай ойлголт нь бусад ойлголтын нэгэн адил тасралтгүй шинэчлэгдэн хөгжиж иржээ. Анх хүн төрөлхтний аман харилцааны хөгжлийн тодорхой шатанд тухайн улс үндэстний хүмүүс хоорондоо өөр өөрийн гэсэн өвөрмөц соёл, онцлогтой тодорхой дүрс, тэмдэг хэрэглэн бичгээр харилцаж, түүх соёлоо хойч үедээ тэмдэглэн үлдээж эхэлснээр үндэстэн бүрийн хэлний үндэс болсон бичиг үсэг, түүний эзэмшилтийг тодорхойлсон бичиг үсэгтэн, бичиг үсгийн боловсрол хэмээх ойлголтууд үүсч бий болжээ. Эдгээр ойлголтууд нь цаг хугацааны болон тухайн нийгэм, хувь хүний хэрэгцээний өөрчлөлт, шинэчлэлийн аясаар байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж иржээ.

Даяарчлал, Локальчлал, Мэдээлэл харилцааны технологийн үсрэнгүй хөгжил, дэлхий нийтээрээ мэдлэгийн шинэ зуунд шилжин орсон, цаг хугацааны болон хэрэгцээний асар хурдацтай өөрчлөлт зэрэг нь боловсролын тухай номлол, үзэл баримтлал, ойлголт харьцангуй шинжтэй болохыг гүнээ ухааран, тэднийг гүнзгийрүүлэн, өөрчлөн шинэчилж, хөгжүүлэхийг зүй ёсоор шаардаж байна. Үүний нэгэн жишээ болгон бичиг үсгийн боловсрол (Literacy) хэмээх ойлголт хэрхэн өргөн утгатай, үе шаттай болж шинэ агуулгаар баяжигдан хөгжиж байгааг уншигч та бүхэнд толилуулж байна.

“Literacy” гэдэг үг нь “Litera” буюу “үсэг” гэсэн латин үгнээс гаралтай юм.

Эрт дээр үеэс өнөөг хүртэл бичиг үсгийн боловсролын тухай ойлголт нь бусад ойлголтын нэгэн адил тасралтгүй шинэчлэгдэн хөгжиж иржээ. Анх хүн төрөлхтний аман харилцааны хөгжлийн тодорхой

шатанд тухайн улс үндэстний хүмүүс хоорондоо өөр өөрийн гэсэн өвөрмөц соёл, онцлогтой тодорхой дүрс, тэмдэг хэрэглэн бичгээр харилцаж, түүх соёлоо хойч үедээ тэмдэглэн үлдээж эхэлснээр үндэстэн бүрийн хэлний үндэс болсон бичиг үсэг, түүний эзэмшилтийг тодорхойлсон бичиг үсэгтэн, бичиг үсгийн боловсрол хэмээх ойлголтууд үүсч бий болжээ. Эдгээр ойлголтууд нь цаг хугацааны болон тухайн нийгэм, хувь хүний хэрэгцээний өөрчлөлт, шинэчлэлийн аясаар байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж иржээ.

Дэлхийн болон бусад орны нэр томъёоны тайлбар тольд бичиг үсгийн боловсролыг хүний “унших, бичих чадвар”-ын түвшин, зэрэг хэмээн тодорхойлсон байгаа юм. Гэхдээ ихэнх хүмүүс саяхан болтол, түүнийг зөвхөн хэл шинжлэлийн асуудал мэтээр ойлгож ирсэн байна. Тухайлбал, бичгийг уншаад, гарын үсгээ зурдаг хүнийг, тухайн хэлний цагаан толгойд бүрэн тайлагдсан хүнийг, өдөр тутмын үйл ажиллагаагаа тодорхойлсон энгийн өгүүлбэрийг уншиж, бичих чадвартай хүнийг, тодорхой түвшний унших бичих тестийг амжилттай өгч чадсан хүнийг, сонин сэтгүүл болон өдөр тутмын амьдрал ахуйд холбогдох зүйлийг унших, бичих чадвартай хүнийг, бага боловсролтой хүнийг, сургуульд 5 буюу түүнээс дээш жил сурсан хүнийг, өөрийн буюу нийгмийн хөгжилд шаардлагатай унших бичих, тоо бодох чадвартай хүнийг, тухайн нийгмийн орчинд ажиллаж амьдрахад шаардлагатай зүйлийг уншдаг, бичдэг чадвартай хүнийг бичиг үсэгтэн буюу бичиг үсгийн боловсролтой хэмээн олон янзаар, харилцан адилгүй тодорхойлон ойлгож ирсэн байна. Мэдээж, хувь хүн бүрийн дээр дурьдсан унших, бичих чадвар харилцан адилгүй учраас тэдгээрийг унших, бичих чадвараар нь тодорхой түвшинд буюу зэрэгт хуваан ангилж болох юм.

1940 оноос эхлэн бичиг үсгийн боловсролыг “Ажил эрхлэх, сургуульд сурах, сонгуульд оролцох, мөргөл үйлдэх гэх мэт нийгмийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай боловсрол” хэмээн тодорхойлсон функциональ бичиг үсгийн боловсрол (functional literacy) гэсэн ойлголт ихээхэн дэлгэрсэн байгаа юм.

Үргэлжлэл. VIII нүүрт

БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛ, ТҮҮНИЙ ТҮВШИН

Төгсгөл Трүүч нь I нүүрт

Б.Хаддамбаа (МУБИС), Б.Болормаа (МУБИС), Л.Энхбаяр (МУБИС)

1990-аад оноос дэлхий нийтээрээ бичиг үсгийн боловсролын түвшинг тогтооход эцэсхэн анхаарах болсон байна. Тухайлбал ямар хүнийг бичиг үсгийн боловсролтой гэх вэ, түүнийг хэрхэн олгох вэ зэрэг асуудлыг маш олон талаас нь олон хэлбэрээр авч үзсэн байгаа юм. Эдгээр ажлууд нь бичиг үсгийн боловсролтой хүнийг сургуульд элсэн орж суралцсан эсэхээр нь буюу ур чадварын тестийг дүнгээр тодорхойлно гэсэн ерөнхий дүгнэлтэнд хүрсэн байна. (Copyright ©1999 University of Pennsylvania, Graduate School of Education, International Literacy Explorer.

<http://www.literacyonline.org/explorer/stats-glossary.html>

Өмнөх тодорхойлолтуудаас харахад бичиг үсгийн боловсрол гэдэг ойлголт нь нэг талаас тухайн хүний бусадтай хамтран ажиллаж амьдрахад зайлшгүй шаардлагатай унших, бичих чадварын түвшингээр, нөгөө талаас түүний боловсролын тодорхой зэргээр тус тус тодорхойлогддог болох нь харагдаж байгаа юм. Мөн бичиг үсгийн боловсрол нь зөвхөн хэл шинжлэлийн ойлголт ч биш, хүний бусадтай хамтран ажиллаж амьдрахад зайлшгүй шаардлагатай, тасралтгүй хөгжин шинэчлэгдэж байдаг ерөнхий унших, бичих чадварын буюу боловсролын түвшин, зэрэг болох нь ч харагдаж байгаа юм.


Хүн төрөлхтний болон тухайн үндэстний тасралтгүй бүтээн бий болгож байдаг шинэ мэдлэг нь тэдгээрийн соёл, боловсролыг байнга өөрчлөн шинэчилж байдаг. Энэхүү өөрчлөлт шинэчлэлийн нөлөөн дор бичиг үсгийн боловсролын агуулга, хамрах хүрээ нь тасралтгүй баяжин хөгжиж байдаг. Шинэ мэдлэг нь тодорхой шинжлэх ухаануудын хүрээнд бүтээгдэн бий болдог бөгөөд тэр нь уг шинжлэх ухааныхаа хэлийг болон хүмүүний ерөнхий унших бичих чадварын буюу боловсролын түвшин зэргийг байнга шинэчилдэг байна. Эндээс бичиг үсгийн боловсрол гэдэг ойлголт нь өөртөө тухайн шинжлэх ухаануудын бичиг үсгийн боловсролыг агуулдаг болох нь харагдаж байгаа юм.

Харин нийгэм хурдацтай хөгжиж дэлхий нийтээрээ даяарчлагдаж байгаа өнөө үед нийгмийн эрэлт хэрэгцээг даган хувь хүнээс өндөр ур чадвартай байхыг шаардаж байна. Иймээс бичиг үсгийн боловсролд зөвхөн ерөнхий унших бичих чадвар гэсэн явцуу хүрээнд бус харин тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролын цогцыг хамруулан өргөн хүрээнд авч үзэх болно.

Сүүлийн жилүүдэд олон судлаачид өөрсдийн бүтээлдээ компьютерийн (computer literacy), математикийн (mathematical literacy), байгалийн ухааны (scientific literacy) бичиг үсгийн боловсрол хэмээх ойлголтыг өргөн хэрэглэх болжээ. Тухайлбал, манай орны зарим судлаачид

өөрсдийн бүтээлдээ "Математик ба байгалийн ухааны сургалтанд гарч байгаа шинэ хандлага нь ... тухайн шинжлэх ухааны суурь мэдлэгийг гүн бат эзэмшүүлэхээс илүүтэйгээр тухайн шинжлэх ухааны суурь боловсролыг нийт ардад төлөвшүүлэхэд түлхүү анхаарч байгаа бөгөөд mathematical literacy, scientific literacy буюу математик, байгалийн ухааны боловсрол, мэдлэг гэсэн нэр томъёо өргөн хэрэглэх болсон гээд ... байгалийн ухааны бичиг үсгийн боловсролтой хүн гэдгийг байгалийн шинжлэх ухааны суурь зарчим, үзэл баримтлалыг ойлгож, байгалийн ухааны талаар таньж мэдсэнээ болон эзэмшсэн ур чадвараа өөртөө ба нийгэмдээ хэрэгтэйгээр ашигладаг хүнийг хэлнэ" гэж тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролыг авч үзсэн байгаа юм (БСШУЯ., МУИС., ЮНЕСКО. (2003) Багш боловсролын хөгжлийн чиг хандлага, стандарт, кириколимийн онол арга зүй. Улаанбаатар., х.67).

Дээрхи байдлаар шинжлэх ухаан тус бүрийн бичиг үсгийн боловсролыг оновчлон тодорхойлж түүнийхээ үндсэн дээр хүмүүний ерөнхий бичиг үсгийн боловсролыг бага, суурь, бүрэн дунд, дипломын, бакалаврын, магистрын, философийн докторын зэрэг боловсролын тодорхой үе шат бүрээр нь ангилан авч үзэх нь өнөөгийн боловсролын өөрчлөлт шинэчлэлийн үндсний үндэс болж байна. Учир нь өнөөгийн бүх шатны боловсролын агуулгын болон үнэлгээний стандарт, хөтөлбөрийг хүмүүний эрэлт хэрэгцээнд бус мэргэжлийн эрдэмтдийн сонирхол хэрэгцээнд тулгуурлан боловсруулж байгаа байдлыг өөрчлөх, сургалтыг прагматчилах, цаг хугацааны болон хэрэгцээний өөрчлөлтийг тухай бүр тооцох зэрэг шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өнөөгийн манай шинэ стандарт ч гэсэн хүмүүний хэрэгцээнд буюу түүнийг тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролд тайлах талаас нь хараагүй зөвхөн мэргэжилтнүүдийн нүдээр харсан, тэдний сонирхолд нийцсэн байдлаар хийгдсэн гэдэгтэй уншигч та бүхнийг санал нийлэх байх гэж бодож байна. Товчоор хэлэхэд бага, суурь, бүрэн дунд болон бусад болов-



ролын үндсэн зорилго, зорилт нь суралцагчийг тухайн шатны байгаль, нийгэм, хүмүүнлэг, техник технологи, урлахуй ухааны бичиг үсгийн боловсролд тайлах асуудал юм. Эл зорилгын үүднээс, юуны өмнө, өнөөгийн бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд судалж буй хичээл бүрийн стандарт, хөтөлбөрийг түүний бичиг үсгийн боловсролын бүтэцчилсэн хүрээг тогтоох замаар эргэн харж оновчлон, тэдгээрийн босоо ба хэвтээ холбоог нарийвчлах шаардлагатай байгаа юм.

Ерөнхий болон тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролын бүтэцчилсэн хүрээг бид доорхи зурагт үзүүлсний дагуу үндсэн ухагдахуун, тэдгээрийн хоорондох хэлний ба хэлний бус холбоог багтаасан агуулгын; унших, бичих, ярих, сонсох, харилцах чадварын нийлэг болсон энгийн чадамжийн; асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх, шинэ мэдлэг бүтээх чадварын нэгдэл болсон бүтээлч чадамжийн гэсэн 3 хэсгээс тогтоно хэмээн үзэж байгаа юм. Эдгээр 3 хэсгийн бүтэц, тухайн чиглэлийн мэргэжлийн үйлийг гүйцэтгэх чадварын хэмжээгээр нь тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролыг бага, суурь, бүрэн дунд, дипломын, бакалаврын, магистрын, философийн докторын гэсэн 7 түвшинд ангилан үзэж болох юм. Тухайн шинжлэх ухааны бага, суурь, бүрэн дунд, дипломын, бакалаврын, магистрын, философийн докторын бичиг үсгийн боловсролын түвшингүүдийн агуулга, энгийн болон бүтээлч чадамжийг нарийвчлан, дахин оновчлон тогтоох нь стандартад суурилсан боловсролын тогтолцооны агуулгын болон үнэлгээний стандартыг шинэчлэн боловсронгуй болгох, боловсролын шатлалуудын хоорондын залгамж болон уялдаа холбоог сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролын агуулга, чадвар

